

“АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР /2008-2012/ “-ИЙН
ХЭРЭГЖИЛТ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БАЙГАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР ӨГСӨН
ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2010-02-10

Дархан-Уул аймаг

МУ-ыг ЗГ-ын 2006 оны 51, 2008 оны 67-р тогтоол, аймгийн ЗДТГ-ын даргын 2009 оны 11–р тушаал, аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжийг тус тус үндэслэн аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг дарга түүний Тамгын газраас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗГХЭГ-ын дарга “ ... **Иргэдээсээ сэтгэл ханамжийн судалгаа, үнэлээг авч, тэдний санал хүсэлтийг зориуд судалж, дүгнэлт хийж байх нь Хурал, Засаг даргын байнга хийх ажил, үйл ажиллагааныхаа үндэслэлийг зөв тодорхойлох үндсэн арга замын нэг байх ёстой ...**” гэсэн зөвлөмж, үүрэг даалгавар өгсөн билээ.

Дээрх зөвлөмж болон ХШҮ-ний тасгийн 2009 оны жилийн ажлын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2009 оны 54-р захирамжаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай журам”-д заасны дагуу “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх ажлыг сумд, агентлагууд улирал бүр зохион байгуулж, тайланг “Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тайлан”-тай хавсарган ирүүлж байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа. Энэ хугацаанд сумд, хэлтэс, агентлагууд нийт 30 гаруй удаа иргэдээс санал асуулга авч, үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан байна.

Хэрэглэгчийн үнэлгээг 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2. Тухайн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа гэсэн 2 чиглэлээр явуулж дүгнэлээ.

Хэрэглэгчийн үнэлгээг сумд, агентлаг бүр өөр өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулсан асуултаар авч дүгнэсэн нь аймгийн нийт дүнг гаргахад хүндрэл учруулж байсны зэрэгцээ социологийн судалгаа, шинжилгээ хийх арга зүйн хувьд зарим нэг учир дутагдалтай талууд ажиглагдаж байлаа. Гэсэн хэдий ч Дархан-Уул аймгийн нийт сумд, хэлтэс, агентлагууд хэрэглэгчийн үнэлгээ хийх ажилд чухал ач холбогдол өгч, аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн ХШҮ-ний тасагтайгаа байнга хамтран ажилласан нь зохих үр дүнгээ өглөө.

Сэтгэл ханамжийн судалгаа буюу хэрэглэгчийн үнэлгээ авах үйл ажиллагаа нь иргэдэд эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгодог, тэдэнд төрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх нөхцлийг бүрдүүлдэг тул тогтмол авч хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж иргэд үзэж байна.

Тухайлбал: Тайлангийн хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын үйл ажиллагааны талаар иргэдээс үнэлгээ авч байх зорилгоор өнгийн хуудсаар санал авах “Саналын хайрцаг”-ийг аймгийн ЗДТГ-т ажиллуулсан нь иргэдийн талархлыг хүлээсэн ажил боллоо. Энэ талаар орон нутгийн ТВ -12 телевизийн 2009 оны 5 дугаарын сарын 8-ны өдрийн “Мэдээллийн хөтөлбөр”-т оролцсон иргэд санал сэтгэгдлээ илэрхийлсэн байна.

Уг хайрцагаар нийт 268 иргэн төрийн албан хаагчийн талаарх үнэлгээ, санал сэтгэгдлээ ирүүлсэн.

Үйлчлүүлэгч иргэдээс төрийн албан хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар амаар болон бичгээр ирүүлсэн санал гомдол, санал хүсэлтийн дэвтэрт үлдээсэн талархлын үг, саналын өнгөт хуудсаар өгсөн үнэлгээ, төрийн албан хаагч болон иргэдийн хоорондох харилцааны зөрчилдөөнтэй асуудлууд, үүнээс үүдэн иргэдээс үзүүлж байгаа хариу үйлдлүүд зэрэг нь хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлдог талаар сумд агентлагуудад чиглэл, зөвлөмж өгч ажилласнаар 2009 онд нэгдсэн буюу хэсэгчилсэн 30 гаруй удаагийн хэрэглэгчийн үнэлгээг зохион байгуулж, нийт 21759 иргэн хамрагдлаа.

Иргэд аймгийн эрүүл мэндийн салбарт 80%, боловсролын салбарт 93,2 %, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 87,32, байгаль орчны салбарт 78,1%, тээвэр, авто замын салбарт 83,5%, хөдөө аж ахуйн салбарт 86,8 %, мэргэжлийн хяналт, стандартын үйлчилгээнд 88,65, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд 75 %, тохижилт үйлчилгээний салбарт 95 %, татвар, төсөв санхүүгийн салбарт 92,85 % үнэлгээг тус тус өгч, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дунджаар хангалттай буюу 87,0 хувийн дундаж үнэлгээ өгсөн байна.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2010 оны 1 сарын 18-ны өдрийн 2-р хуралдаанаар аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн ХШҮ-ний тасгаас хэлтэс, сумд болон агентлагийн дарга нарын 2009 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн талаарх тайланг хэлэлцүүлсний зэрэгцээ дараах зөвлөмжийг гаргасан. Үүнд:

1. ХШҮ-ний тасгаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар боловсруулж гаргасан “Зөвлөмж”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах
2. Сум агентлаг бүр ХШҮ-ний багаа сайн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх, улирал жилийн мэдээ, тайланд баг бүрэн бүрэлдэхүүнээрээ ХШҮнэлгээ хийж, баталгаажуулан ирүүлж байх,
3. ХШҮ-ний багийн мэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэгийг байнга дээшлүүлэх,
4. Бодлогын хэрэгжилт, үр дүнд шинжилгээ, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг хөгжүүлэх,
5. Хэлтэс, сумд, агентлаг бүр үйл ажиллагааны үр дүнд “Ногоон карт- шалгуур үзүүлэлт”-ийн үйлчилгээг нэвтрүүлэх,
6. Хэрэглэгчийн үнэлгээг иргэд, ТББ-ын оролцоо, дэмжлэгтэйгээр хийж, улирал бүр ирүүлж байх,

Дээрх зөвлөмжийг баталгаажуулж, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаас 1. Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасаг нь хяналт-шинжилгээ, үнэлгээг улирал бүр хийж, үр дүнг тооцох, мэргэжил, арга зүйн зөвөлгөө өгөх, танилцуулах, 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээг улам боловсронгуй болгох талаар идэвхи санаачлага гаргаж ажиллах талаар тус тус үүрэг даалгавар өгсөн.

2010 онд Хэрэглэгчийн үнэлгээг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг боловсронгуй болгох, сумд, агентлагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилгоор “Хэрэглэгчийн үнэлгээний журам”-ыг шинээр боловсруулж байгаа бөгөөд уг журмаар сумд, агентлагуудын хэрэглэгчийн үнэлгээ авах ерөнхий загварыг батлахаар төлөвлөж байна.

МУЗГ-ын 2010 оны 11-р тогтоолоор батлагдсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын 5 дахь хэсгийн 5.9 –т заасны дагуу Хэрэглэгчийн үнэлгээний ажлыг аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа ТББ-ууд, мэргэжлийн судалгааны байгууллагатай хамтран зохион байгуулахаар судалгаа авч байна.

ТАНИЛЦСАН: ТЗУХ-ИЙН
ДАРГА

Б. АРЪЯА

ХЯНАСАН: ХШҮ-НИЙ ТАСГИЙН
ДАРГА

Д. ЖАРГАЛСАЙХАН

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ТЗУХ-ИЙН ХШҮ-НИЙ ТАСГИЙН
МЭРГЭЖИЛТЭН

О. БУЯНАА